



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 4 сарын 27 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Санал авах байр бэлтгэх заавар батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.9 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.9 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. “Санал авах байр бэлтгэх заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү зааврыг мөрдөж ажиллахыг сум, дүүргийн Засаг дарга, сонгуулийн хороодын дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Санал авах байрыг бэлтгэх заавар, санал бэлтгэх бүхээгийн хэмжээ, загвар батлах тухай” 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ч. Содномцэрэн


Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц. Болдсайхан

Ц.БОЛДСАЙХАН

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 4 дугаар сарын 27-ны өдрийн
45 дугаар тогтоолын хавсралт



САНАЛ АВАХ БАЙР БЭЛТГЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Санал авах байр бэлтгэхэд сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэхүү зааврыг мөрдлөг болгоно.

1.2.Санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй ашиглуулна.

Хоёр. Санал авах байрыг бэлтгэх

2.1.Сум, дүүргийн Засаг дарга санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө санал авах байрыг бэлтгэж, хэсгийн хороонд хүлээлгэн өгнө.

2.2.Санал авах байранд дараах зүйлсийг бэлтгэсэн байна:

2.2.1.Төрийн далбаа;

2.2.2.сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах хоёроос доошгүй бүхээг;

2.2.3.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг;

2.2.4.суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг;

2.2.5.сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц;

2.2.6.харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас, томруулдаг шил;

2.2.7.саналын хуудаст саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар;

2.2.8.саналын хуудаст санал тэмдэглэх зориулалтын үзэг;

2.2.9.хэсгийн хорооны бүрэлдэхүүн болон мэдээллийн технологийн даамал, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан ажиллахад хүрэлцэхүйц тооны ширээ, сандал, утас, факс, компьютер, принтер;

2.2.10.цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй хэсэгт цахилгаан үүсгүүр;

2.2.11.ажиглагчдын ширээ, сандал;

2.2.12.саналын хуудсыг хадгалах сэйф, лацны тэмдэг;

2.2.13.мэргэжлийн байгууллагын зөвлөмжид заасан халдвар хамгаалал, ариутгалын хэрэгсэл;

2.2.14.хууль тогтоомжид заасан бусад.

2.3.Санал авах байр бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

2.4.Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.

2.5.Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулж болно. Хяналтын камерыг сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд саад учруулахгүйгээр байрлуулна.

2.6.Санал авах байрны гадна Монгол Улсын Төрийн далбааг байрлуулж,
“..... сонгуулийн тойргийн
..... дугаар хэсгийн санал авах байр” гэсэн хаягтай байна.

Гурав. Санал авах байрны эрүүл ахуй, аюулгүй байдал

3.1.Санал авах байранд санал тоолох төхөөрөмж, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл болон саналын хуудас хүлээн авснаас хойш тухайн санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна.

3.2.Санал авах байрны харуул хамгаалалт, аюулгүй байдлыг сонгуулийн хороод, тухайн шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, онцгой байдлын алба хариуцан гал, усны зэрэг гэнэтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

3.3.Санал авах байрны дотор болон гадна орчныг гэрэлтүүлэг сайтай байхаар бэлтгэсэн байна.

3.4.Санал авах байрны зохион байгуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу тухайн шатны Засаг дарга мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэнэ.

3.5.Санал авах байрыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчдод мэдэгдэнэ.

---oOo---